



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2022/02-НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363047 Цахим хаяг: <a href="mailto:Otgongbayarts@audit.gov.mn">Otgongbayarts@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТББ	Төрийн бус байгууллага
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
СХС	Сум хөгжүүлэх сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
АҮТХ	Ажил, үйлчилгээний төлбөр хураамж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	14
3.5.1. Мөнгөн хөрөнгө.....	14
3.5.2. Авлага .....	14
3.5.3. Бараа материал.....	15
3.5.4. Үндсэн хөрөнгө .....	16
3.5.5. Өр төлбөр .....	17
3.5.6. Засгийн газрын хувь оролцоо.....	17
3.5.7. Зарлагын данс.....	18
3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга.....	19
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	21
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	21
3.6.3 Нэмэлт төсөв.....	22
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	23
3.8. Аудитын гол асуудал .....	24
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....	24
3.9.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	24
3.9.2. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	24
3.10. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	25
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	26
4. Аудитын илрүүлэлт .....	26
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	30



Б А Р У У Н Б Ü Р Э Н С У М Ы Н З А С А Г  
Д А Р Г А Ц. С Э Л Э Н Г Э Т А Н А А

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/02-НА-СТА-ТТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДÜГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	797,289.7	991,220.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	350,057.5	497,660.6
33	АВЛАГА	158,838.1	123,180.5
35	БАРАА МАТЕРИАЛ	288,394.1	370,379.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,027,032.6	3,936,342.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,027,032.6	3,936,342.4
39200	Биет хөрөнгө	3,956,022.1	3,867,114.4
39300	Биет бус хөрөнгө	71,010.5	69,228.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,824,322.3</b>	<b>4,927,563.0</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,880.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,880.8
41300	Өглөг	0.0	1,880.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,824,322.3	4,925,682.2
51	Засгийн газрын хувь оролцоо	4,824,322.3	4,925,682.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,245,916.6	1,245,916.6
51200	Хуримтлагдсан үр дүн	2,440,856.0	2,542,215.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,137,549.7	1,137,549.7
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,824,322.3</b>	<b>4,927,563.0</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,983,708.7	3,274,304.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	434,230.6	329,055.1
110	Орлогын албан татвар	70,520.9	77,721.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	70,520.9	77,721.4
113	Хөрөнгийн албан татвар	1,138.0	169,029.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	362,571.6	82,303.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	554,998.4	358,426.9
120	Нийтлэг татварын бус орлого	554,998.4	358,426.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,994,479.8	2,586,822.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,458,796.8	2,958,276.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,458,796.8	2,958,276.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,525,513.3	2,817,943.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,481,807.9	1,575,827.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,065.1	208,509.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,948.5	212,346.3
2104	Хангамж, бараа материалын зардал	88,794.2	104,859.0
2105	Нормативт зардал	145,626.0	237,050.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,989.6	18,075.9
2107	Томилолт, зочны зардал	2,919.4	2,137.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,019.5</b>	<b>30,123.6</b>

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	362,343.0	429,013.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	933,283.5	140,332.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	524,911.9	316,027.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	401,425.8	193,327.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	430,113.4	122,699.9

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	3,511,871.9	3,079,579.1
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	434,230.6	329,055.1
110	Орлогын албан татвар	70,520.9	77,721.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	70,520.9	77,721.4
113	Хөрөнгийн албан татвар	1,138.0	169,029.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	362,571.6	82,303.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,089.6	13,522.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	338,482.0	68,781.1
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	83,161.6	170,384.8
120	Нийтлэг татварын бус орлого	83,161.6	170,384.8
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,994,479.8	2,580,139.2
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,154,107.5	2,624,984.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,154,107.5	2,624,984.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,221,254.8	2,484,651.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,481,807.9	1,574,837.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,065.1	208,309.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,948.5	212,250.7
2104	Хангамж, бараа материалын зардал	83,769.6	94,669.3
2105	Нормативт зардал	131,257.3	227,124.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,274.3	23,982.5
2107	Томилолт, зочны зардал	2,919.4	2,137.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,400.6	35,124.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,812.0	106,217.4
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	932,852.7	140,332.6
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	357,764.4	454,594.6
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	193,344.2	239,991.6
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	193,344.2	239,991.6
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	193,344.2	239,991.6
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-193,344.2	-239,991.6
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	0.0	-67,000.0
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	0.0	67,000.0
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	164,420.2	147,603.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	185,637.4	350,057.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	350,057.5	497,660.6

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,394,208.9	0.0	4,394,208.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,394,208.9	0.0	4,394,208.9
9	Тайлант үеийн үр дүн	430,113.4	0.0	430,113.4
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>4,824,322.3</b>	<b>0.0</b>	<b>4,824,322.3</b>
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,824,322.3	0.0	4,824,322.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,040.0	0.0	-1,040.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,823,282.3	0.0	4,823,282.3
19	Тайлант үеийн үр дүн	122,699.9	0.0	122,699.9
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	<b>4,925,682.2</b>	<b>0.0</b>	<b>4,925,682.2</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,031,781.10</b>	<b>2,606,189.00</b>	<b>425,592.10</b>	<b>85.96</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,562,452.60</b>	<b>2,388,095.30</b>	<b>174,357.30</b>	<b>93.20</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,510,442.10</b>	<b>2,340,233.70</b>	<b>170,208.40</b>	<b>93.22</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,585,403.00</b>	<b>1,539,566.30</b>	<b>45,836.70</b>	<b>97.11</b>
210101	Үндсэн цалин	1,065,326.70	1,077,315.30	-11,988.60	101.13
210102	Нэмэгдэл	377,656.70	327,262.80	50,393.90	86.66
210104	Урамшуулал	79,402.60	77,142.50	2,260.10	97.15
210105	Гэрээт ажлын хөлс	63,017.00	57,845.70	5,171.30	91.79
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>214,331.40</b>	<b>203,737.00</b>	<b>10,594.40</b>	<b>95.06</b>
210201	Тэтгэврийн даатгал	149,780.20	142,402.40	7,377.80	95.07
210202	Тэтгэмжийн даатгал	16,137.80	15,807.20	330.60	97.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,910.50	12,373.60	536.90	95.84
210204	Ажилгүйдлийн даатгал	3,227.30	3,012.80	214.50	93.35
210205	Эрүүл мэндийн даатгал	32,275.60	30,140.90	2,134.70	93.39
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>245,895.10</b>	<b>210,073.90</b>	<b>35,821.20</b>	<b>85.43</b>
210301	Гэрэл, цахилгаан	32,623.40	22,281.50	10,341.90	68.30
210302	Түлш, халаалт	198,831.30	168,732.00	30,099.30	84.86
210303	Цэвэр, бохир ус	14,440.40	19,060.40	-4,620.00	131.99
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>81,772.20</b>	<b>80,158.10</b>	<b>1,614.10</b>	<b>98.03</b>
210401	Бичиг хэрэг	11,014.80	11,046.80	-32.00	100.29
210402	Тээвэр, шатахуун	47,178.80	46,567.30	611.50	98.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,600.90	9,400.40	200.50	97.91
210404	Ном, хэвлэл	689.40	581.20	108.20	84.31
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,233.80	6,536.60	697.20	90.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,054.50	6,025.80	28.70	99.53

**Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>126,697.40</b>	<b>90,869.10</b>	<b>35,828.30</b>	<b>71.72</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,397.20	29,911.90	8,485.30	77.90
210502	Хоол, хүнс	73,407.30	46,064.50	27,342.80	62.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,892.90	14,892.70	0.20	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>118,256.60</b>	<b>96,090.40</b>	<b>22,166.20</b>	<b>81.26</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,163.30	47,132.30	1,031.00	97.86
210602	Тавилга	23,628.80	17,128.80	6,500.00	72.49
210604	Урсгал засвар	46,464.50	31,829.40	14,635.10	68.50
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,554,000.00</b>	<b>1,957,400.00</b>	<b>2,596,600.00</b>	<b>42.98</b>
210702	Дотоод албан томилолт	4,554.00	1,957.40	2,596.60	42.98
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>28,752.60</b>	<b>22,437.70</b>	<b>6,314.90</b>	<b>78.04</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,215.80	20,109.90	5,105.90	79.75
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,664.00	1,494.00	1,170.00	56.08
210803	Даатгалын үйлчилгээ	317.10	306.60	10.50	96.69
210804	Тээврийн хэрэгслийн татвар	303.20	288.20	15.00	95.05
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	246.00	239.00	7.00	97.15
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>104,779.80</b>	<b>95,343.70</b>	<b>9,436.10</b>	<b>90.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,219.80	90,783.70	9,436.10	90.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,560.00	4,560.00	0.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,010.50</b>	<b>47,861.50</b>	<b>4,149.00</b>	<b>92.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>52,010.50</b>	<b>47,861.50</b>	<b>4,149.00</b>	<b>92.02</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,668.00	27,004.80	3,663.20	88.06
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,215.00	16,215.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,127.50	4,641.70	485.80	90.53
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>321,128.50</b>	<b>151,093.70</b>	<b>170,034.80</b>	<b>47.05</b>
220001	Барилга байгууламж	201,892.50	110,122.90	91,769.60	54.55
221001	Их засвар	41,000.00	40,970.80	29.20	99.93
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>148,200.00</b>	<b>67,000.00</b>	<b>81,200.00</b>	<b>45.21</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	148,200.00	67,000.00	81,200.00	45.21
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,031,781.10</b>	<b>2,690,767.80</b>	<b>341,013.30</b>	<b>88.75</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,595,752.70</b>	<b>1,529,926.80</b>	<b>65,825.90</b>	<b>95.87</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,595,752.70	1,529,926.80	65,825.90	95.87
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,144,873.20</b>	<b>1,002,398.70</b>	<b>142,474.50</b>	<b>87.56</b>
320001	Орон нутгийн төсвөөс	996,125.10	853,650.60	142,474.50	85.70
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	148,748.10	148,748.10	0.00	100.00

<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>32,195.80</b>	<b>16,382.80</b>	<b>15,813.00</b>	<b>50.88</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,195.80	16,382.80	15,813.00	50.88
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>258,959.40</b>	<b>142,059.30</b>	<b>116,900.10</b>	<b>54.86</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,815.00	142,059.30	43,755.70	76.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	123,385.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	207,963.70		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>8</b>	<b>8</b>		<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	8	8		100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>136</b>	<b>136</b>		<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	16	16		100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	77	73		94.81
620003	Үйлчлэх ажилтан	35	39		111.43
620004	Гэрээт ажилтан	8	8		100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>136</b>	<b>136</b>		<b>100.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10		100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	61	61		100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	6	6		100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21	21		100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	32		100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6		100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>263,206.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>263,206.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>233,315.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>35,270.80</b>
210101	Үндсэн цалин	33,282.30
210104	Урамшуулал	1,988.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,571.90</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,126.60
210202	Тэтгэмжийн даатгал	357.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	282.30
210204	Ажилгүйдлийн даатгал	65.30
210205	Эрүүл мэндийн даатгал	740.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,176.80</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,176.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,059.60</b>
210401	Бичиг хэрэг	3,727.10
210402	Тээвэр, шатахуун	9,889.70

**Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,304.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>136,254.90</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	133,462.60
210502	Хоол, хүнс	2,792.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,681.10</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2.50
210604	Урсгал засвар	5,678.60
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>180.00</b>
210702	Дотоод албан томилолт	180.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,237.30</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,237.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,883.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,883.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,890.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,534.70</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,534.70
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,355.80</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,110.60
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,245.20
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>263,206.40</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>263,206.40</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	36,041.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,168.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,572.20
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	137,645.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	39,779.50

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Баруунбүрэн сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх, татварын тайланд цалин хөлсийг бүрэн тайлагнах, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, ХХОАТ-ын тайланд цалин хөлсийг бүрэн тайлагнаж байх, тээврийн хэрэгслийн ашиглалтын дэвтрийг хөтлөх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын Засаг дарга ИТХ-ыг цаг үеэ олсон зөвлөгөө мэдээллээр мэргэшлийн өндөр түвшинд хангаж үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг эрхэмлэн иргэдэд ойр захиргааг бий болгох” гэж тодорхойлсон бөгөөд эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сумын санхүүгийн албаны дарга нь оны эхэнд Засаг даргаар төсөвт байгууллагууд болон төрийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг батлуулан, дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Тайлант жилийн хугацаанд аймгийн СТСХ болон Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

### **3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,999,247.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 44,988.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 33,741.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 350,057.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 497,660.6 мянган төгрөг болж, 147,603.1 мянган төгрөгөөр өссөн байна. Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	350,057.5	497,660.6	147,603.1	29.6
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>350,057.5</b>	<b>497,660.6</b>	<b>147,603.1</b>	<b>29.6</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын дансанд 289,696.8 мянган төгрөг, ОНХС-д 131,936.5 мянган төгрөг, СХС-д 75,980.5 мянган төгрөг, ЭМТ-д 46.7 мянган төгрөг нийт 497,660.6 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

#### Аудитын илрүүлэлт:

ЕБС нь 2021 оны 12 сарын 23-нд жижиг мөнгөн кассын хэмжээг хэтрүүлэн 4,767.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 158,838.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 125,061.2 мянган төгрөг болж, 33,776.9 мянган төгрөгөөр буурсан байна. Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	550.00	200.00	(350.00)
Зээлийн хүүгийн авлага	6,390.10	3,242.10	(3,148.00)
Байгууллагаас авах авлага	-	5,632.80	5,632.80
Хувь хүмүүсээс авах авлага	4,066.70	4,066.70	-
Хувь хүмүүст олгосон зээл	147,831.30	110,038.90	(37,792.40)
<b>Дүн</b>	<b>158,838.10</b>	<b>123,180.50</b>	<b>(35,657.60)</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд ЕБС-тай холбоотой ажиллагчидтай холбогдсон авлага 550.0 мянган төгрөгөөр буурч, ЭМТ нь урьдчилгаа цалинг дутуу суутгаснаас шинээр 200.0 мянга төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Байгууллагаас авах авлага 5,632.8 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ нь төрөөс хариуцах 12 сарын цэвэр усны төлбөрийн санхүүжилт 1,522.6 мянган төгрөгийг, ЭМТ нь ЭМД-ын сангаас авах 4,110.2 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагыг тус тус бүртгэснээс шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 52,364.2 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- СХС-ийн зээлийн 46,127.3 мянган төгрөгийн, зээлийн хүүгийн 2,170.2 мянган төгрөгийн, нийт 48,297.5 мянган төгрөгийн авлага,
- 2013 онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас ногоочдод олгож байсан Итгэлийн зээлийн 4,066.7 мянган төгрөгийн авлага байна.

СХС-аас олгосон зээлийг Монгол банкны мэдээллийн санд оруулдаг болсноор 2021 онд хугацаа хэтэрсэн 27 зээлдэгчийн 109,817.7 мянган төгрөгийн зээл бүрэн төлөгдөж хаагдсан бөгөөд тайлант онд шүүхэд 5, ШШГГ-т 1 зээлдэгчийн материалыг хүргүүлсэн, 2 зээлдэгчтэй эвлэрлийн гэрээ байгуулсан байна.

### Аудитын илрүүлэлт:

ЭМТ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 200.0 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон авлага үүсгэсэн байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 288,394.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 370,379.4 мянган төгрөг болж, 81,985.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	18,533.20	23,972.50	5,439.30
Эм боох материал	20,303.90	23,858.20	3,554.30
Бэлэн бүтээгдэхүүн			-
Бичиг хэргийн материал	18,752.90	20,406.10	1,653.20

Аж ахуйн материал	230,404.10	231,434.30	1,030.20
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал	-	-	-
Хүнсний материал	-	1,277.00	1,277.00
Бусад хангамжийн материал	400.00	69,431.30	69,031.30
<b>Дүн</b>	<b>288,394.10</b>	<b>370,379.40</b>	<b>81,985.30</b>

*Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 81.985.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 638,038.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, хандив, тусламжаар 51,664.6 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авсан, үнэ төлбөргүйгээр 92,044.3 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авсан зэргээр нийт 783,189.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 670,697.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 20,300.0 мянган төгрөгийн бараа материалыг данснаас дансанд шилжүүлэн, 10,206.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна Үүнд:

- ИТХ нь 8,560.0 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 35,263.8 мянган төгрөгийн,
- Соёлын төв нь 6,325.6 мянган төгрөгийн,
- Ойн анги нь 12,325.6 мянган төгрөгийн,
- ЭМТ нь 28,963.5 мянган төгрөгийн,
- Цэцэрлэг 19,475.0 мянган төгрөгийн гэх мэт.

**3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 5,114,830.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,349,675.1 мянган төгрөг болж 234,844.8 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл**

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,842,910.90	2,899,235.90	56,325.00
Хуримтлагдсан элэгдэл	(223,298.50)	(347,779.40)	(124,480.90)
Авто-тээврийн хэрэгсэл	302,557.90	297,673.90	(4,884.00)
Хуримтлагдсан элэгдэл	(174,777.50)	(198,018.50)	(23,241.00)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	478,380.20	552,994.30	74,614.10
Хуримтлагдсан элэгдэл	(255,618.40)	(316,864.70)	(61,246.30)
Тавилга, аж ахуйн эд хогшил	351,587.10	403,951.40	52,364.30
Хуримтлагдсан элэгдэл	(173,840.60)	(211,587.20)	(37,746.60)
Бусад үндсэн хөрөнгө	980,979.30	1,029,712.50	48,733.20

Хуримтлагдсан элэгдэл	(256,689.30)	(333,726.90)	(77,037.60)
Ном	83,831.00	91,523.10	7,692.10
Программ хангамж	10,620.00	10,620.00	-
Хуримтлагдсан элэгдэл	(3,573.30)	(5,355.80)	(1,782.50)
Бусад биет бус хөрөнгө	63,963.80	63,963.80	-
<b>Дүн</b>	<b>4,027,032.60</b>	<b>3,936,342.40</b>	<b>(90,690.20)</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 88,897,8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив, тусламжаар 25,036.5 мянган төгрөгийн, данснаас дансанд шилжүүлэн авсан 20,300.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 105,494.4 мянган төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдэж, 4,884.0 мянган төгрөгийн хөрөнгө актлагдаж, данснаас хасагдсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэлгүй байсан бол тайлант оны эцэст 1,880.7 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон өглөг	-	1,880.70	1,880.70
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>1,880.70</b>	<b>1,880.70</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төрөөс хариуцах цэвэр усны төлбөр төрийн сангийн гүйлгээ хаагдсанаас хойш орж ирснээс шалтгаалан тайлант онд 1,880.7 мянган төгрөгийн гэрээт ажилтнуудын / усан сангийн ажилтнууд / цалингийн өглөг үүссэн байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,824,322.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4,925,682.2 мянган төгрөг болж, 101,359.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,245,916.60	1,245,916.60	-	-
Өмнөх үеийн үр дүн	2,010,742.60	2,419,516.00	408,773.40	20.30
Тайлант үеийн үр дүн	430,113.40	122,699.90	(307,413.50)	(28.50)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,137,549.70	1,137,549.70	-	
<b>Дүн</b>	<b>4,824,322.30</b>	<b>4,925,682.20</b>	<b>101,359.90</b>	<b>2.10</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,925,682.2 мянган төгрөг болж, 101,359.9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

### 3.5.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **50,732.1** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

##### **ТТЗ :**

- TV-8 телевизтэй "Монголоороо аялцагая" нэвтрүүлгийн гэрээ байгуулж, 5,000.0 мянган төгрөгийн, "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачилга" ТББ-тэй "Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах" гэрээ байгуулж 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон.
- Сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/178 дугаар захирамжаар урсгал зардлаас хөрөнгийн зардалд буюу ЗДТГ-ын цалин болон тогтмол зардлын хэмнэлтээс багаж, техник, хэрэгслийн зардалд 10,000.0 мянган төгрөг, Ойн ангийн цалингийн зардлын хэмнэлтээс тавилга, эд хогшлын зардалд 1,128.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн зохицуулалт хийсэн байна.

##### **ЗДТГ:**

- Холбогдох албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1,520.0 мянган төгрөгийг багаж, техник, хэрэгсэл худалдан авч, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- Автомашины сэлбэг болон засварын 6,580.8 мянган төгрөгийн зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт, км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй байна.

##### **ЭМТ:**

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас "Ковид-19"-тэй холбоотой илүү цагийн хөлсийг олгохдоо 888.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлт илүү тооцож, авлага үүсгэсэн.
- "Ковид-19"-тэй холбоотой илүү цагийн 17,675.0 мянган төгрөгийн цалинг ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан,
- Автомашины сэлбэг болон засварын 2,939.0 мянган төгрөгийн зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Баруунбүрэн сумын ИТХ-ын “2021 оны төсөв батлах тухай” 2020 оны 09 дүгээр тогтоолоор тайлант онд 217,590.0 мянган төгрөгийн татварын орлого, 20,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 357,380.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 50.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №.7 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Сумын төсвийн татварын орлого</b>	<b>217,590.00</b>	<b>329,055.00</b>	<b>111,465.00</b>	<b>151.23</b>
Үйл ажиллагааны орлого	35,000.00	36,456.90	1,456.90	104.16
Хөрөнгийн орлого	5,852.00	27,533.40	21,681.40	470.50
Хөрөнгө борлуулсны орлого	800.00	13,731.00	12,931.00	1,716.38
Бууны албан татвар	1,200.00	1,299.00	99.00	108.25
Малд ногдуулах албан татвар		167,730.90	167,730.90	
Улсын тэмдэгтийн хураамж	5,000.00	8,851.70	3,851.70	177.03
Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	200.00	2,832.00	2,632.00	1,416.00
Хог хаягдал үйлчилгээ	2,000.00	1,839.00	(161.00)	91.95
Газрын төлбөр	15,118.00	-	(15,118.00)	-
Ойн нөөц ашигласны төлбөр	37,768.00	55,994.80	18,226.80	148.26
Агнуурын нөөц ашигласны төлбөр	2,262.00	995.00	(1,267.00)	43.99
Байгалийн ургамал ашигласны төлбөр	112,390.00	11,791.30	(100,598.70)	10.49
<b>Сумын төсвийн татварын бус орлого</b>	<b>20,000.00</b>	<b>28,325.60</b>	<b>8,325.60</b>	<b>141.63</b>
Бусад орлого	5,000.00	4,473.10	(526.90)	89.46
Торгуулийн орлого	15,000.00	23,852.50	8,852.50	159.02
<b>Дүн</b>	<b>237,590.00</b>	<b>357,380.60</b>	<b>119,790.60</b>	<b>150.42</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд хөрөнгийн орлого 21,681.4 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 18,226.8 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 12,931.0 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 8,852.6 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 3,851.7 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 2,632.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 1,456.9 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төлөвлөгдөөгүй орлого болох малд ногдуулах албан татварын орлогоор 167,730.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

#### Давж биелсэн орлогууд:

- Хөрөнгийн орлого 21,681.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь урьд жилүүдэд Сайхан суманд төвлөрдөг байсан бол тайлант жилд тус сумын дансанд төвлөрснөөс шалтгаалсан,
- Ойн нөөц ашигласны төлбөр 18,226.8 мянган төгрөгөөр давсан нь ЗГ-ын тогтоолоор гоожингийн М<sup>3</sup>-ийн үнэ 2.5-3.2 дахин өссөнтэй холбоотой,
- Хөрөнгө борлуулсны орлого 12,931.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь тус суманд нотариатын үйлчилгээ тогтмол хийгдэж, үл хөдлөх хөрөнгийн болон бусад хөрөнгийн гэрээ сумандаа хийгдэж байгаатай холбоотой,
- Торгуулийн орлого 8,852.6 мянган төгрөгөөр давсан нь замын хөдөлгөөний зөрчил их гарсантай холбоотой,

### **Тасарсан орлого:**

- Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 100,598.7 мянган төгрөгөөр тасарсан нь тайлант жилд сумын бүс нутагт самар ургаагүйгээс шалтгаалсан,
- Газрын төлбөрийн орлого 15,118.0 мянган төгрөгөөр тасарсан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 2,972,174.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09, 10 дугаар тогтоолоор нийт эх үүсвэр болон зардлыг 2,972,174.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсөвт хийгдсэн нийт 2 удаагийн тодотгол болон зохицуулалтаар дараах өөрчлөлтүүд орж сумын төсөв **3,015,934.4** мянган төгрөгөөр эцэслэн батлагдсан байна. Үүнд:

- **ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 24 дүгээр тогтоол:**
  - ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөөг 1,890.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн цалингийн зардлыг тодотгосон,
  - ОНХС-ийн эхний үлдэгдлээс 20,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн “Халуун усны халаалтын систем, тоног төхөөрөмж худалдан авах” төсөл, арга хэмжээг нэмж баталсан,

- Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих ЕБС-ийн санхүүжилтийг 67,248.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цэцэрлэгийн санхүүжилтийг 15,459.0 мянган төгрөгөөр бууруулсан,
- Аймгаас суманд өгөх санхүүгийн дэмжлэгээс Спорт цогцолборын тогтмол зардлыг 34,920.3 мянган төгрөгөөр бууруулж, ЭМТ-ийн тогтмол зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- **Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/178 дугаар захирамжаар :**
  - ЗДТГ нь цалин болон тогтмол зардлын хэмнэлтээс багаж, техник, хэрэгслийн зардалд 10,000.0 мянган төгрөгийг,
  - Ойн анги нь цалингийн зардлын хэмнэлтээс тавилгын зардалд 1,128.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төсөвт зохицуулалт хийсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын ИТХ-ын тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 3,015,934.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөвт өөрчлөлт орсноор **3,031,781.1** мянган төгрөгөөр эцэслэн батлагдаж 2,560,652.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 321,128.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 150,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоожээ.

Нийт зардлын 1,595,752.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 32,195.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 556,049.1 мянган төгрөгийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс, 387,590.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 202,486.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 35,815.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 148,748.1 мянган төгрөгийг ОНХС-аас, 73,144.4 мянган төгрөгийг ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,529,926.8 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 556,049.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 297,601.5 мянган төгрөг, ОНХС-аас 148,748.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 16,382.8 мянган төгрөг, болон туслах үйл ажиллагааны орлогоос 29,052.4 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 113,006.9 мянган төгрөг зэрэг нийт **2,690,767.7** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,606,189.0** мянган төгрөг буюу 85.9 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 56,431.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35,821.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 1,614.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 35,828.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 22,166.1 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 2,596.6 мянган төгрөгөөр, бусдаар

гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 6,314.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 9,436.1 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 4,149.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 170,034.7 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 81,200.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээнд 99,236.0 мянган төгрөг олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 2 төсөл, арга хэмжээнд 40,970.8 мянган төгрөг санхүүжилт олгогдсон байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 10 төсөл, арга хэмжээнд 221,892.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 110,122.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, оны эхний зарцуулагдаагүй үлдэгдлийн хамт 131,936.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Дээд шатны төсвийн захирагчдаас 7,641.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 76,710.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 137,645.0 мянган төгрөг, иргэн хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд өгсөн хандив 36,041.6 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 5,168.1 мянган төгрөг, нийт 263,206.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-т аймгийн ЗДНХ-өөс шүлхий өвчинтэй холбоотой зардалд **5,168.1 мянган** төгрөг,
- Мал эмнэлгийн газраас малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,000.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн малын тооллогын зардалд 1,094.4 мянган төгрөг, аймгийн ХХААГ-аас ургац хураалтын дүн мэдээ нэгтгэлийн шатахууны зардалд 300.0 мянган төгрөг, сумын ИТХ-д аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 300.0 мянган төгрөг, Цэцэрлэгт аймгийн БСУГ-аас халдваргүйжүүлэлтийн зардалд 152.0 мянган төгрөг, ЕБС-д боловсролын чанарын шинэчлэлийн төслийн санхүүжилтэд 4,795.0 мянган төгрөг зэрэг нийт **7,641.4 мянган** төгрөгийг тус тус шилжүүлсэн,
- Сумын ЭМТ-д аймгийн ЭМГ-аас цар тахлын үед томилолтоор ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс 18,987.8 мянган төгрөг, ЭМС-ын тушаалаар мөнгөн тэтгэмж 24,600.0 мянган төгрөг, ЭМДЕГ-аас, вакцины санхүүжилт 27,756.1 мянган төгрөг, гэрийн хяналтын санхүүжилт 5,366.4 мянган төгрөг нийт **76,710.3 мянган** төгрөг,
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг тодруулбал ЗДТГ нь Гавшгай ус ААТҮГ-аас айл өрхийн цэвэр усны зардал 16,748.8 мянган төгрөг, цахим тендерийн хураамжийн орлого 287.3 мянган төгрөг, актлагдсан машины дуудлага худалдааны орлого 600.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын ажлын техник, хяналтын орлого 287.8 мянган төгрөг, ЭМТ нь оношлуурын 11,994.1 мянган төгрөг, эмийн сангийн орлого 103,051.4 мянган төгрөг, ЕБС нь түрээсийн номны орлого 2,369.8 мянган төгрөг, цэцэрлэг нь тендерийн орлого 72.0 мянган төгрөг, Орхон бүсийн сум дундын

Ойн анги нь талбай тусгаарлалтын орлого 2,233.8 мянган төгрөг нийт **137,645.0 мянган** төгрөгийг тус тус төвлөрүүлсэн,

- Иргэн, хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулан ЗДТГ-т хандивласан 30,936.0 мянган төгрөг, ЭМТ-д 5,105.6 мянган төгрөг нийт **36,041.6 мянган** төгрөгийн хандив тусламжийн орлого төвлөрсөн байна.

Үүнээс цалингийн зардалд 35,270.8 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 4,571.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2,176.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 15,059.6 мянган төгрөг, нормативт зардалд 136,254.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 5,681.1 мянган төгрөг, томилолтын зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 17,237.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 16,883.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 25,534.7 мянган төгрөгийг зарцуулж, 4,355.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**3.7.1** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ**”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно”, 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-ээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа” гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ЗДТГ-ын нягтлан бодогч Б.Оюунгэрэлийн Бургалтай САА-д ажиллаж байсан 6 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор аймгийн СТСХ-ээс хянаж, ирүүлсний дагуу нийт 4,632.8 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Дээр дурдсан Бургалтай САА нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

**3.7.2** Иргэн, хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулан ЗДТГ-т хандивласан 30,936.0 мянган төгрөг, ЭМТ-д 5,105.6 мянган төгрөг нийт **36,041.6 мянган** төгрөгийн хандив тусламжийн орлого төвлөрсөн байна. Үүнээс ЗДТГ 16,016.0 мянган төгрөгийг, ЭМТ 732.9 мянган төгрөгийг бэлнээр авч сумын Онцгой комиссын шийдвэрээр зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

1. ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн усны орлогоос худаг ажиллуулж байгаа 4 ажилтнуудтай хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага дүнгээр сарын 210.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 7,380.9 мянган төгрөгийн цалин олгосон байна.

2. Сумын 2021 оны төсөвт төвлөрүүлэх орлого болон төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагуудын зарлагын дүнд өөрчлөлт ороогүй байхад Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 30 дугаар “Тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор сумын нийт орлого, зарлагын дүнг дахин баталсан байна.

3. Сумын ИТХ-ын төсвийн төлөвлөгөөгөөр ИТХ-ын нарийн бичгийн дарга М.Мөнхсайханд ХАСХОМ хариуцсан ЭБАТ-ын нэмэгдлийг жилд 1 удаа 40 хувиар тооцож, олгохоор батлагдсан байхад сар бүр 20 хувиар тооцож 1,570.0 мянган төгрөг илүү олгосон бөгөөд үүнээс шалтгаалан оны эцэст 1,730.8 мянган төгрөгийн цалингийн өр төлбөр үүсэхэд сумын ЗДТГ-ын цалингийн зардлын хэмнэлтээс тус байгууллагын цалингийн зардлыг нэмэгдүүлэн төсөвт зохицуулалт хийсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. ТТЗ нь нийт 79 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 4 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
2. ЗДТГ нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 4 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
3. ИТХ нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 4 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
4. Ойн анги нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 3 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
5. Соёлын төв нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 3 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
6. ЭМТ нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

#### Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 62,228.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 63,705.9 мянган төгрөгийг зарцуулан, батлагдсан төсвийг 1,477.7 мянган төгрөгөөр хэтрүүлсэн,
- Цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 449,045.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 424,920.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.4 хувиар хэмнэсэн,
- Сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 919,952.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 852,418.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.1 хувиар хэмнэсэн,

Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2. ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т: “.....бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг дараах байгууллагууд зөрчсөн байна. Үүнд:

- ИТХ нь 1,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил,
- Ойн анги нь 1,128.8 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан байна.

### 3.10 Өмнөх аудитаар өгсөн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 675.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 26,532.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	675.40	1	675.40	-	-	100
Зөвлөмж	2	26,532.50	2	26,532.50	-	-	100
<b>Нийт</b>	<b>3</b>	<b>27207.9</b>	<b>3</b>	<b>27207.9</b>	-	-	<b>100</b>

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

### 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 7, орон нутгийн төсөл сангийн 2, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс, ЕБС, цэцэрлэгийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 5 байгууллага, 2 төсөл сангийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Баруунбүрэн сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 238,547.4 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илрүүлснээс 71,664.6 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 23,737.3 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага өгч, 143,145.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 213,030.9 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илрүүлснээс 70,660.3 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 23,737.3 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага өгч, 118,633.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүллээ.

#### 4.1 Залруулга:

Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаанаас үүссэн 70,660.3 мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг аудитын явцад илрүүлж, санхүүгийн тайланд залруулга хийлгэв. Үүнд:

#### ЗДТГ:

- “Ковид-19” цар тахлын үед иргэн, ААНБ-аас өгсөн мөнгөн хандивын орлого 1,050.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан,
- Төрөөс хариуцах цэвэр усны төлбөрийн 12 дугаар сарын санхүүжилтийн авлага 1,522.6 мянган төгрөгийг дутуу тайлагнасан,
- Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон тендерийн орлого 87.8 мянган төгрөгийг данс буруу ангилан бүртгэсэн.

#### ЭМТ:

- ЭМД-ын сангаас авах 12 дугаар сарын ковидын санхүүжилтийн авлага 4,110.2 мянга төгрөгийг дутуу тайлагнасан.

## ОНХС:

- ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэж буй “ Сургуулийн биеийн тамирын гадна талбай шинэчлэх” дуусаагүй ажлын тайлант онд олгогдсон санхүүжилт 63,889.7 мянган төгрөгийг бараа материалын үлдэгдлээр тайлагнаагүй.

### 4.1 АЛБАН ШААРДЛАГА

1. Сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/178 дугаар захирамжаар урсгал зардлаас хөрөнгийн зардалд буюу ЗДТГ-ын цалин болон тогтмол зардлын хэмнэлтээс багаж, техник, хэрэгслийн зардалд 10,000.0 мянган төгрөг, Ойн ангийн цалингийн зардлын хэмнэлтээс тавилга, эд хогшлын зардалд 1,128.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн зохицуулалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7 дахь “ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгаадаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зохицуулалтыг хууль, эрхийн актад нийцүүлэн хийж байх албан шаардлага хүргүүлэх.

2. TV-8 телевизтэй "Монголоороо аялцгаая" нэвтрүүлгийн гэрээ байгуулж, 5,000.0 мянган төгрөгийн, "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачилга" ТББ-тэй "Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах" гэрээ байгуулж 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон байна. Эдгээр зөрчлүүд нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1 дэх “Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна”, 2.1.5 “... Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ”, 7.1 дэх “ Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

3. ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардлаас 1,520.0 мянган төгрөгийн багаж, техник, хэрэгсэл худалдан авч, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

4. ЭМТ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ахлах сувилагч Л.Батлхагвад 200.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгоод буцаан суутгаагүй авлага үүсгэсэн, "Ковид-19"-тэй холбоотой илүү цагийн хөлсийг олгохдоо 888.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлт илүү тооцож авлага үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог хянан баталгаажуулах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд ИТХ нь 8,560.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 35,263.8 мянган төгрөгийн, Соёлын төв нь 6,325.6 мянган төгрөгийн, Ойн анги нь 12,325.6 мянган төгрөгийн, ЭМТ нь 28,963.5 мянган төгрөгийн зэрэг нийт **91,438.5** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасныг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

#### 2. ХХОАТ-ын тайлангийн тайлагналтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: ЭМТ нь "Ковид-19"-тэй холбоотой илүү цагийн 17,675.0 мянган төгрөгийн цалинг ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Цаашид ХХОАТ-ын тайланд цалин хөлсийг үнэн зөв тайлагнаж байх.

### **3.Зардлын данстай холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт: ЗДТГ нь 6,580.8 мянга төгрөгийн , ЭМТ нь 2,939.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй байна. Энэ нь Стандартчилал, Хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 51 дүгээр тогтоолоор баталсан заавал мөрдөх “Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт” MNS 4601-2011 стандартыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Цаашид авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтөлж, урсгал болон их засвар, нийт км, шатахуун зарцуулалтуудын тооцоог бүрэн бүртгэн, авто механикийн хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>															
1	ТТЗ		Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	1	10,000.00					1	10,000.0				
6	ТТЗ		ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн АУТХ-ын зардлаас багаж, техник, хэрэгслийн зардалд санхүүжүүлсэн.	1	1,520.00					1	1,520.0				
2	ТТЗ		Урсгал зардлаас хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр төсвийн зохицуулалт хийсэн.	1	11,128.8					1	11,128.8				
4	ТТЗ	СЗА-2022/02-НА-СТА-ТТЗ	ЭМТ нь төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн	1	1,088.50					1	1,088.5				
7	ТТЗ		ИТХ, ЗДТГ, ЭМТ, Соёлын төв, Ойн анги зэрэг байгууллагууд бараа материалын худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, ЭМТ нь илүү цагийн хөлсийг ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан байна.	1	91,438.50									1	91,438.5
8	ТТЗ		ЭМТ нь илүү цагийн хөлсийг ХХОАТ-ын тайланд дутуу тайлагнасан байна.	1	17,675.00									1	17,675.0

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	ТТЗ	ЗДТГ болон ЭМТ нь автомашины сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгээгүй.	1	9,519.80												1	9,519.8	
10	ТТЗ	ЗДТГ нь "Ковид-19" цар тахлын үед иргэн, ААНБ-аас өгсөн мөнгөн хандивын орлогыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан.	1	1,050.00	1	1,050.0												
11	ТТЗ	ЗДТГ нь төрөөс хариуцах цэвэр усны төлбөрийн санхүүжилтийн авлагыг дутуу тайлагнасан.	1	1,522.60	1	1,522.6												
12	ТТЗ	ЗДТГ нь Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон тендерийн орлогыг данс буруу ангилан бүртгэсэн.	1	87.8	1	87.8												
13	ТТЗ	ЭМТ нь ЭМД-ын сангаас авах ковидын санхүүжилтийн авлагыг дутуу тайлагнасан.	1	4,110.20	1	4,110.2												
14	ТТЗ	ОНХС-ийн санхүүжилтээр хийгдэж буй " Сургуулийн биеийн тамирын гадна талбай шинэчлэх" дуусаагүй ажлыг бараа материалын үлдэгдлээр тайлагнаагүй.	1	63,889.70	1	63,889.7												
<b>ДҮН</b>			<b>12</b>	<b>213,030.9</b>	<b>5</b>	<b>70,660.3</b>								<b>4</b>	<b>23,737.3</b>	<b>3</b>	<b>118,633.3</b>	
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>																		
1	ТТЗ	СЭА-2022/02-НА-	ТТЗ, ЗДТГ, ИТХ, Ойн анги, Соёлын төв, ЭМТ зэрэг байгууллагууд шилэн	1	-											1	-	

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	СТА-ТТЗ	дансны мэдээллийг хугацаа хоцроосон буюу ОГТ мэдээлээгүй.	1	-	2	1	-	3	118,633.3
		3Г-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй.	1	-	2	1	-	3	
			2			2	-		
<b>ДҮН</b>			<b>14</b>	<b>213,030.9</b>	<b>5</b>	<b>70,660.3</b>	<b>6</b>	<b>23,737.3</b>	<b>1</b>
<b>НИЙТ ДҮН</b>									<b>3</b>
									<b>118,633.3</b>